



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ БҮХ
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТЭН НАРТ

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2024. 07. 24 № 10/3027
танай _____-ны № _____-т

Мэдээлэл, санал ирүүлэх тухай

Тус яамнаас санаачлан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн Эрүүл мэндийг дэмжих сан, түүний хөрөнгийг зарцуулахтай холбоотой хэсэгт нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, 2023 онд Монгол Улсын Их Хурлаар батлуулсан. Уг өөрчлөлтөөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зохицуулалт туссан.

Мөн "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ыг Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор баталсан /<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089772439811/>.

Тус яамнаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны 2024-2025 оны тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулж байна. Энэ тэргүүлэх чиглэлийг боловсруулахад хэрэгцээтэй дор дурдсан мэдээллийг яамны салбар зөвлөл тус бүр боловсруулж ирүүлнэ үү. Үүнд:

1. эрүүл мэндийн тусламж үйлчилгээний аль чиглэл, салбарт ямар төрлийн дэвшилтэт технологиуд хаана хаана нэвтэрсэн, түүнийг манай улсын хаана (төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлгүүд) нэвтрүүлэх хэрэгцээтэй болон боломжтой байгаа тухай дэлгэрэнгүй танилцуулга,
2. аль эмнэлэгт нэвтэрч нутагшсан ямар технологи, үйл ажиллагааг аль аймаг, орон нутгийн ямар байгууллагад нэвтрүүлэн нутагшуулах боломжтой тухай мэдээлэл, санал,
3. танай салбар чиглэлд хамааралтай 2024-2025 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх шаардлагатай дэвшилтэт технологи, үйл ажиллагааны санал (3 хүртэлх тооны).

Иймд дээрх танилцуулга, мэдээлэл, саналыг бэлтгэн салбар зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлж, 8 дугаар сарын 10-ны өдөрт багтаан тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ үү.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.МӨНХСАЙХАН

141425018